



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 09 сарын 07 өдөр

Дугаар 121

Номгон

“Эрүүл мэндийн ажилтны хөгжил”  
аймгийн дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.9 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Эрүүл мэндийн ажилтны хөгжил” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тухайн жилийн төсөвт тусгаж байхыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д үүрэг болгосугай.


3. Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, мөрдүүлэн, хэрэгжүүлэх ажлыг эрчимтэй зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс /Л.Баясгалангомбо/, Эрүүл мэндийн газрын дарга /А.Ганболд/, Нэгдсэн эмнэлгийн дарга/ Н.Баттогтох/ нарт тус тус даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

0117033



**“ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ ХӨГЖИЛ”  
АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР /2017-2019 ОН/**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Хүн амын дунд зонхилон тохиолдож буй өвчлөлийн ерөнхий хандлага, төвлөрөл, шилжилт хөдөлгөөн зэрэг хүчин зүйлүүд нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шинэ шинэ хэрэгцээг бий болгож байгаатай уялдан үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээг хангахуйц мэргэжлийн ур чадвартай, ёс зүй төлөвшсөн хүний нөөцийг сургаж, зохистой харьцаагаар байршуулах, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, чанартай тусламж үйлчилгээг оновчтой зохион байгуулах шаардлага эрүүл мэндийн салбарын өмнө тавигдаж байна.

Аймгийн эрүүл мэндийн салбарын хэмжээнд 2016 оны байдлаар эрүүл мэндийн 92 байгууллага, нэгжид 1166 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ажиллаж байгаагийн 172 буюу 14.8 хувийг их эмч, 2.9 хувийг эмнэлгийн бусад дээд мэргэжилтэн, 48.2 хувийг эмнэлгийн дунд мэргэжилтэн, 33,3 хувийг бусад ажилчид эзэлж нийт ажиллагсдын 46,8 хувь нь анхан шатлалын, 29,7 хувь нь хоёрдогч шатлалын, 6,0 хувь нь хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж нийт ажиллагсдын 80,4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Эрүүл мэндийн салбарын ажиллагсдын дунд 2016 онд хийсэн нийгмийн баталгааны суурь судалгаанд нийт ажиллагсдын 81 хувь нь буюу 945 хүн хамрагдсанаас 27.4 хувь нь өрх толгойлсон, 86.5 хувь нь ямар нэгэн зээлтэй, 13.3 хувь нь орон сууцны зээлд хамрагдахыг хүссэн байна.

Салбарын хэмжээнд 2013-2016 онуудад жил бүр төрийн сангийн зардлаар төгсөлтийн дараах мэргэжил эзэмшүүлэх сургалтад суралцагчдын тоог нэмэгдүүлэхийн зэрэгцээ “Шинэ зууны эмч” орон нутгийн дэд хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлснээр дутагдалтай байсан их эмчийн хангалтыг нэмэгдүүлж, хэрэгцээтэй мэргэжлээр сургаж ажиллуулснаар Нэгдсэн эмнэлэг шаардлагатай нарийн мэргэжлийн эмчээр, сум дундын эмнэлгүүд хүүхэд, эмэгтэйчүүд, мэс засал, дотор зэрэг 3-5 үндсэн мэргэжлийн эмчээр, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд 2-4 их эмчээр тус тус хангагдаад байна.

Цаашид аймгийн Нэгдсэн эмнэлэгт эмгэг судлаач, элэг судлаач, эрэгтэйчүүдийн өвчин судлал, дурангийн мэс засал судлал зэрэг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нар, сум дундын эмнэлгүүдэд нүүр ам судлалын, дотрын, сумын эрүүл мэндийн төвүүдэд хүүхэд эмэгтэйчүүдийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд мэдрэлийн үндсэн мэргэжлийн

эмч нарыг сургаж ажиллуулах, Бууцагаан сумын эрүүл мэндийн төвийн материаллаг баазыг түшиглэн Баруун бүсийн яаралтай тусламжийн төв байгуулах асуудлыг шийдвэрлүүлж, шаардлагатай мэргэжлийн эмч, мэргэжилтнүүдийг сургах шаардлагатай байна.

Салбарын хэмжээнд хөрөнгө оруулалт, хүний нөөцийн хангамж, тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж, хүртээмж сайжирч байгаа хэдий ч ажиллагсдын хариуцлага сахилгыг сайжруулах, мэргэжлийн ур чадварыг дэмжихэд чиглэсэн цалин урамшууллын хөшүүрэг хангалтгүй, нийгмийн асуудлыг бүрэн шийдвэрлэж чадаагүй, эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд ёс зүй, харилцаа хандлага жигд төлөвшөөгүй зэрэг тулгамдсан асуудлууд нь бодлогын түвшинд хэрэгжүүлж байгаа зорилтуудын үр дүнд нөлөөлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж нэмэгдэхгүй гомдол, санал гарсаар байна.

Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны үр дүн нь технологийн шинэчлэл, тоног төхөөрөмж, хүний нөөцийн хангалтаас гадна нийт ажиллагсад, эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, мэргэжлийн ур чадварын түвшин, ёс зүй, харилцаа хандлагын төлөвшил, ажиллах нөхцөл, тогтвор суурьшил зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай байгаа учраас тэдний нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх, мэргэшүүлж сургах, цалин, урамшууллын хөшүүргээр ажлын хариуцлага, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх нь эмч, эрүүл мэндийн ажилтнуудыг идэвхжүүлж, тусламж үйлчилгээний чанар, үр дүнг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй гэж үзэж байна.

Иймээс эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэхэд тулгамдаж буй бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд орон нутгийн оролцоо, салбар дундын хамтын ажиллагаа, төрийн бус байгууллагуудын дэмжлэгийг авч, үр дүнтэй хамтран ажиллах зорилгоор “Эрүүл мэндийн ажилтны хөгжил” аймгийн дэд хөтөлбөрийг боловсрууллаа.

#### ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, шаардлагыг хангасан өндөр ур чадвартай, ёс зүй, харилцаа, хандлага төлөвшсөн эмч, эрүүл мэндийн ажилтнуудыг тусламж үйлчилгээний шатлал бүрд зохистой харьцаагаар байршуулан, нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэж, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулж, хүн бүрт чанартай хүртээмжтэй үйлчлэхэд оршино.

#### ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

Салбарын хэмжээнд эмч, эмнэлгийн дээд мэргэжилтэн, сувилагч, багийн эмч бусад тусгай мэргэжилтнүүдийг стандартын дагуу ханган ажиллуулж, төгсөлтийн дараах болон ажлын байрны сургалтад хамруулан мэргэжил, ур чадварыг дээшлүүлэн иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламжийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх

Сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн бусад ажиллагсадыг ажлын байрны сургалтуудад үе шаттайгаар хамруулах

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлагын тогтолцоог жигд төлөвшүүлэхэд чиглэгдсэн сургалт, сурталчилгааг сайжруулах

Эрүүл мэндийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл боломж, нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэхэд орон нутгийн дэмжлэгт оролцоо, удирдлагын манлайллыг нэмэгдүүлэх.

Мэргэжил олгох, мэргэшүүлэх, ажлын байрны сургалтын санхүүгийн дэмжлэгийг шийдвэрлүүлэх

### ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1 Салбарын хэмжээнд тусламж үйлчилгээний шатлал тус бүрт нэн шаардлагатай мэргэжлээр эмч мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэх, төрөлжсөн төв эмнэлгүүдтэй эмч солилцон ажиллуулж ур чадварыг нэмэгдүүлэх

4.2 Өндөр хөгжилтэй улс орнуудад жил бүр 20 хүртэлх эрүүл мэндийн ажилтныг мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх сургалтад хамруулах, туршлага судлуулах

4.3 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг нийгмийн эрүүл мэндийн ажилтнаар хангаж ажиллуулах

4.4 Эрүүл мэндийн ажилтнуудад “Эерэг харилцаа, хандлагын нэмэгдэл” олгох журам боловсруулан хэрэгжүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг төлөвшүүлэх сургалт сурталчилгааг өргөжүүлж, хариуцлагын тогтолцоог сайжруулах

4.5 Удирдах албан тушаалд болон мэргэжлээрээ олон жил үр бүтээлтэй ажилласан туршлага, мэргэжил ур чадварын зохих шаардлагыг хангасан ахмад мэргэжилтнүүдээс бүрдсэн “Зөвлөх баг”-г бүрдүүлж, эрүүл мэндийн байгууллагуудын залуу мэргэжилтэн, удирдах албан тушаалтан, хамт олонд зөвлөн тусалж, ажиллуулах

4.6 Эрүүл мэндийн байгууллагын үндсэн үзүүлэлтүүдийг “Хангалттай сайн” түвшинд тогтвортой хүргэж, дэмжлэгт удирдлагаар хангаж ажилласан сумын Засаг даргыг “Эрүүл мэндэд ээлтэй Засаг дарга”-аар жил бүр шалгаруулж, аймгийн Засаг даргын шагналаар урамшуулах

4.7 Орон нутагт тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтнүүд болон тухайн жилд онцгой ур чадвар гаргаж тусламж үйлчилгээ үзүүлж, хүний амь нас, эрүүл мэндийг аварсан эмч, багийн хамт олноос жил бүр “Манлай эмч”, “Манлай сувилагч” шалгаруулж, аймгийн Засаг даргын нэрэмжит шагналаар урамшуулах

4.8 Эрүүл мэндийн салбарт 10 түүнээс дээш жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй салбар хамт олноо манлайлан ажилласан, орон сууцтай болоход дэмжлэг хүссэн

5 хүртэлх ажилтныг жил бүр шалгаруулж, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 5 саяас доошгүй төгрөгийн 1 удаагийн хөнгөлөлтөд хамруулах

#### ТАВ. ХҮРЭХ ҮР ДҮН

5.1 Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоо сайжирч, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн дэмжлэгт оролцоо нэмэгдсэн байна.

5.2 Өндөр ур чадвартай, ёс зүй, харилцаа хандлага жигд төлөвшсөн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг зохистой харьцаагаар байршуулж ажиллуулснаар иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээ хангагдаж, сэтгэл ханамж нэмэгдэнэ.

5.3 Эрүүл мэндийн салбарын ажиллагсдын нийгмийн асуудал үе шаттайгаар шийдвэрлэгдэж, ажлын байрны ээлтэй орчин бүрдсэнээр ажиллагсдын сэтгэл ханамж, ажлын хариуцлага, сахилга сайжирч тусламж үйлчилгээний чанар үр дүн дээшилнэ.

5.4 Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нэн шаардлагатай байгаа мэргэжлийн эмч нарыг мэргэшүүлж сурган, ажиллуулснаар хоёрдугаар шатлалын тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, гуравдугаар шатлалын эмнэлэгт шилжиж үйлчлүүлэх иргэдийн хэрэгцээ, шаардлага буурна.

5.5 Сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд үндсэн мэргэжлийн эмч нарыг сургаж, ажиллуулснаар анхан шатлалд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, оношилгоо, эмчилгээний чадамж дээшилж, үйлчилгээний ачаалал, төвлөрөл, үйлчлүүлэгчдийн хүлээгдэл, чирэгдэл багасаж, Нэгдсэн эмнэлэг шатлалын дагуу үйл ажиллагаа явуулах боломж бүрдэнэ.

#### ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

6.1 Эмнэлгийн мэргэжилтний хэрэгцээг хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, хорогдол зэрэг эрсдэлт хүчин зүйл, хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл, нас баралт, эрүүл мэндийн салбарын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан төлөвлөн хэрэгжүүлнэ.

6.2 Энэхүү стратегийг 2017-2020 онд хэрэгжүүлэх бөгөөд үндэсний болон орон нутгийн түвшинд баримталж байгаа дараах бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилтуудтай уялдсан байна. Үүнд:

1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын баримт бичиг
2. “Төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл индекс батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/184 дүгээр тушаал
3. Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого
4. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

5. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон орон нутгийн эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэхэд баримталж буй бодлого чиглэл

**ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

7.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, оролцогч талуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих, хэрэгжилтийн явцыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнах, шаардлагатай асуудлаар холбогдох газарт санал оруулах асуудлыг аймгийн Эрүүл мэндийн газар хүлээнэ.

**НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ**

8.1 Хөтөлбөрийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн үндсэн эх үүсвэрийг орон нутгийн төсөв болон төсөл хөтөлбөрийн зардал, олон улсын байгууллагын хандив, тусламжаас санхүүжүүлнэ.

8.2 Нэмэлт хөрөнгийн эх үүсвэрийг эрүүл мэндийн салбарын жил бүрийн төрийн сангийн сургалтын батлагдсан зардлаас санхүүжүүлнэ.

**ЕС. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

9.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавих, хяналт-шинжилгээ, үнэлгээг аймгийн Эрүүл мэндийн газар гүйцэтгэнэ.

9.2 Шаардлагатай гэж үзвэл хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

9.3 Хөтөлбөрийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ.

9.4 Хөтөлбөрийн шалгуур

№	Шалгуур үзүүлэлт	2016 оны түвшин	2020 онд хүрэх түвшин	Үзүүлэлтийн үнэлгээ
1	Сум дундын эмнэлэг, сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн шаардлагатай үндсэн мэргэжлийн /дотор, мэс засал, хүүхэд, эмэгтэйчүүд, унтуулга/ эмчээр хангагдсан хувь	66,6	100 хувь	Хүний нөөцийн тайлан
2	Шаардлагатай мэргэжлийн чиглэлээр өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтнүүдийн эзлэх хувь	0,2	0,5	Хүний нөөцийн тайлан
3	Нэгдсэн эмнэлгийн үндсэн мэргэжлийн эмчийн хангалтын хувь	65,6	75,0	Хүний нөөцийн тайлан
4	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нийгмийн ажилтны хангалтын хувь	20,0	100,0	Хүний нөөцийн тайлан
5	Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан нийгмийн эрүүл мэндийн ажилтны эзлэх хувь	-	100,0	Хүний нөөцийн тайлан
6	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн алдаа зөрчлийн тоо			Хүний нөөцийн тайлан

7	Ажлын байрны сургалтад хамрагдсан эмнэлгийн бусад ажилтнуудын эзлэх хувь	3,0	10,0	Хүний нөөцийн тайлан
8	Орон сууцанд шинээр орсон болон орон сууцны нөхцлөө сайжруулсан эрүүл мэндийн ажилтны эзлэх хувь	3,6	8,0	Нийгмийн баталгааны суурь судалгаа
9	Эрүүл мэндийн ажилтнуудын ажлын байрны зэрэг сэтгэл ханамжийн хувь	-	70,0	Сэтгэл ханамжийн судалгаа
10	Иргэдийн зэрэг сэтгэл ханамжийн хувь	40.0	65.0	Сэтгэл ханамжийн судалгаа
11	Зөвлөх баг ажиллах хувь	35.0	60.0	Сэтгэл ханамжийн судалгаа